

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1 Оршил | 4 |
| 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 7 |
| 2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 7 |
| 2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 8 |
| 2.12 Шилэн дансны мэдээлэл..... | 8 |
| 2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 8 |
| 2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 8 |
| 3. Менежментийн захидал | 10 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 13 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 13 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 14 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 16 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 17 |
| 4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан | 18 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн Тайлангийн Аудит |
| ТХН | Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ТӨСВИЙН САНХҮҮГИЙН
УДИРДЛАГА ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ
БАЙДАЛ ТӨСӨЛ”-ИЙН ЗАХИРАЛ
Г.ТҮВДЭНДОРЖ ТАНАА

2020 Оч 24 № 06/1305
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 136,218.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал Г.Түвдэндорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах, шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрт байршуулах зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 02-ноос 2020 оны 4 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн Аудитор Б.Алтансарнай, туслах аудитор Б.Эрдэнэболд нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн зорилго нь Татварын удирдлага болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоог оновчтой болгоход дэмжлэг үзүүлэх, Татварын удирдлага болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын мэдээлэл холбооны технологийн тогтолцоог сайжруулах, төсвийн нэгдсэн мэдээллийн систем ба төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн системүүдийг хариуцан ажиллах Засгийн газрын ажилтнуудыг чадавхжуулахад оршино.

Санхүүгийн эх үүсвэр: Азийн хөгжлийн банк

Зээлийн хэмжээ: 25,000,000 ам.доллар

Хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам

Хэрэгжиж эхэлсэн огноо: 2018/11/21

Төсөл хэрэгжиж дуусах огноо: 2023/03/30

Тайлант онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог Сангийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 14-ний 25 тоот тушаалаар баталж, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлуудыг эхлүүлэн төслийн урьдчилгаа санхүүжилтийг Азийн хөгжлийн банкнаас 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Татварын ерөнхий газрын хотын бүсийн болон орон нутгийн бүсийн нийт 9 албан хаагч 2019 оны 11 дүгээр сарын 7-ны өдрөөс 13-ний өдрүүдэд Дани улсын татварын ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцах сургалтад оролцсон.
- Татварын ерөнхий газрын сумдын байцаагч нарын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан ба нийт 365 байцаагч хамрагдсан.
- Татварын ерөнхий газрын мэдээлэл технологийн газрын 2 мэргэжилтэн мэргэжил дээшлүүлэх 21 хоногийн сертификаттай сургалтад Энэтхэг улсын Дэли хотноо хамрагдсан.
- Сангийн яамны мэдээлэл технологийн 2 ажилтан Япон улсын Токио хотноо Дата төвийн зураг төсөв боловсруулах 3 өдрийн сургалтад хамрагдсан.
- Татварын ерөнхий газрын дата төв болон нөөц төвд мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр байгуулан, урьдчилгаа төлбөрийг олгосон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” нь нягтлан бодох бүртгэлийн бодлогогүй боловч нягтлан бодох бүртгэлээ хөтлөхдөө Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар”, санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн

сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар”-ыг дагаж мөрдөж байгаа нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 599,355.8 мянган төгрөгөөс тооцон 11,987.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог Сангийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 14-ний 25 тоот тушаалаар баталж, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 131 тоот тушаалаар томилсноор төслийн үйл ажиллагаа эхэлсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| | /мянган төгрөг/ | | |
|---|-----------------|--------------------|--------------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 3,953,288.7 | 3,953,288.7 |
| Авлага | - | 4,440.0 | 4,440.0 |
| Урьдчилж гарсан зардал | - | 862,240.5 | 862,240.5 |
| Үндсэн хөрөнгө | - | 74,829.0 | 74,829.0 |
| Биет бус хөрөнгө | - | 7,932.9 | 7,932.9 |
| Нийт хөрөнгө | - | 4,902,731.1 | 4,902,731.1 |
| Өр төлбөр | - | 5,771.8 | 5,771.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | - | 4,896,959.3 | 4,896,959.3 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | - | 4,902,731.1 | 4,902,731.1 |

Авлага данс: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффисын 1 сарын түрээсийн барьцаа төлбөрийг бүртгэсэн байна.

Урьдчилж төлсөн зардал данс: Татварын ерөнхий газрын дата төв болон нөөц төвд мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулах гэрээний урьдчилгаа төлбөрийг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө данс: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффисын тавилга, тоног төхөөрөмжийг бүртгэсэн байна. Хөрөнгө оруулалтаар 86,454.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан.

Биет бус хөрөнгө данс: 8,422.4 мянган төгрөгийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн программ худалдан авсныг бүртгэсэн байна.

Өр төлбөр данс: 5,071.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгийг бүртгэсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд “Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийг хэрэгжүүлэхэд зориулан 3,606,427.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 929,690.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлыг Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 5,317,796.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Азийн хөгжлийн банкнаас авч, харилцах дансны хүүгийн орлого 52,485.8 мянга, бусад орлого 3,635.0 мянга, нийт 5,373,950.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,486,800.5 мянган төгрөгийг зарцуулж, 3,953,288.7 мянган төгрөгийн төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,486,800.5 мянган төгрөг буюу 41 хувьтай байна. Төслийн зээлийн гэрээний дагуу 2018 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжихээр төлөвлөж, төсвийг баталсан боловч төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг Сангийн яамнаас 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр томилсонтой холбоотойгоор тайлант онд төлөвлөсөн ажлууд хойшлогдсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 141,358.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,140.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 136,218.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах, анхан шатны баримтын иж бүрдлийг сайжруулах, шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулах талаар 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 5,140.0 мянган төгрөгийн дараах асуудлыг залруулав. Үүнд:

2. Оффисын түрээсийн барьцаа:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффисын түрээсийн 1 сарын барьцаа төлбөрт шилжүүлсэн 4,440.0 мянган төгрөгийг зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3 дугаар зүйлийн 3.2-д *"Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын дансуудад хуримтлуулан бүртгэнэ. Аккруэл суурьт бүртгэлийн хувьд ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ."* гэсэн заалтад нийцэхгүй, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

3. Цалингийн бүртгэл:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалинг давтан тооцоолж үзэхэд төслийн зохицуулагчийн цалинг шинэчлэгдсэн цалинд үндэслэн тооцоогүйгээс 700.0 мянган төгрөгөөр дутуу тооцон олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3 дугаар зүйлийн 3.2-д *"...төсөл, тусгай сангийн гарсан зардлыг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээ болон зохих анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ."* гэж заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төслийн зээлийн гэрээний дагуу төслийн үйл ажиллагаа 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэхээр заасан боловч Сангийн яамнаас төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг 2019 оны 5 дугаар сард томилсонтой холбоотойгоор төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцролтой явагдаж, тайлант онд хэрэгжүүлэх ажлууд хойшлогдсон байгаа тул дараагийн аудитаар төслийн үйл ажиллагаанд анхаарал хандуулах шаардлагатай байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт 11 төрлийн мэдээллийг оруулж 3 мэдээллийг нь хугацаа хоцроож оруулсан ба батлагдсан нийт төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Төсөл нь шинээр 2019 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн тул хамааралгүй болно.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж,

баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл” (Зээл-3709-МОН)-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төслийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө

3.1.1 Илрүүлэлт:

Төслийн зээлийн гэрээний дагуу төслийн үйл ажиллагаа 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэхээр төлөвлөсөн боловч Сангийн яамнаас төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг 2019 оны 5 дугаар сард томилсонтой холбоотойгоор төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцролтой явагдаж байгаа нь Төслийн зээлийн гэрээний хавсралт “Төслийн удирдлагын гарын авлага”-д заасан Төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаандаа явагдахгүй, төслийн хэрэгжилт удаашрах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийг зээлийн гэрээнд заасан хугацаанд нь үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх тал дээр хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцролтой явагдаж байгаа нь Төслийн гэрээний хавсралт болох Төслийн удирдлагын гарын авлагын төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд нийцэхгүй байгаа боловч энэ асуудал дээр Азийн хөгжлийн банкинд албан ёсны тайлбар хүргүүлсэн байна.

3.2 Анхан шатны баримт

3.2.1. Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэх нэгж 92,772.3 мянган төгрөгийн е-баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтандаа хавсаргаагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.3 ““анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Харилцагч байгууллагууд санхүүгийн болон татварын тайланд орлогоо тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах эрсдэлтэй.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Төслийн үйл ажиллагаанд хийгдсэн худалдан авалтын е-баримтыг харилцагч байгууллагаас авч, анхан шатны баримтанд хавсаргах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч цаашид дахин ийм зөрчил гаргахгүй болно.

3.3 Шилэн дансны мэдээллийн хэрэгжилт

3.3.1 Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь шилэн дансны сайтад нийт 11 мэдээллийг байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан буюу батлагдсан нийт төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлэг 6 дугаар зүйл “Шилэн дансны мэдээлэл”-д заасан заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Мэдээллийн ил тод байдлыг хангахгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн дагаж мөрдөж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч цаашид дахин ийм зөрчил гаргахгүй болно.

3.4 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффисын түрээс

3.4.1 Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн түрээсэлж буй 120 м.кв оффисын байрны түрээсийн 1м.кв-ийн сарын тариф нь 37.0 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн хязгаараас 840.0 мянган төгрөгөөр өндөр буюу тайлант онд нийт 5,880.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг илүү төлсөн байгаа нь 2018

оны 1 дүгээр сарын 9-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны тэмдэглэлийн 1.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн 1м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг 30,000 (гучин мянган) төгрөгөөс ихгүй байлгах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Зээлийн хөрөнгийн хэмнэлтгүй зарцуулах.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффисын түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн хязгаарт багтаах талаар зохих арга хэмжээ авч ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч цаашид дахин ийм зөрчил гаргахгүй болно.

3.5 Анхан шатны баримтын бүрдэл

3.5.1 Илрүүлэлт:

2019 оны 8 дугаар сард зохион байгуулсан Татварын ерөнхий газрын удирдлагууд болон сумдын татварын улсын байцаагчдын сургалтын оролцогчдод олгосон 37,566.4 мянган төгрөгийн замын унааны зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй буюу унааны мөнгийг сургалтанд оролцогчид олгосон эсэх нь тодорхой бус байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Зээлийн хөрөнгийн зориулалтын бусаар зарцуулах.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид төслийн хүрээнд зохион байгуулах сургалтуудын анхан шатны баримтын иж бүрдэлд анхаарч ажиллах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч цаашид дахин ийм зөрчил гаргахгүй болно.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|----------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | - | 4,819,969,239.60 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 3,953,288,730.80 |
| 31100 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | 500,000.00 |
| 31110 | Төгрөг | - | 500,000.00 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 3,952,788,730.80 |
| 31210 | Төгрөг | - | 1,946,894,606.27 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 1,922,478,583.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 24,416,023.27 |
| 31220 | Гадаад валют | - | 2,005,894,124.53 |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | - | 2,005,894,124.53 |
| 33 | АВЛАГА | - | 4,440,000.00 |
| 33500 | Бусад авлага | - | 4,440,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 4,440,000.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 862,240,508.80 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 862,240,508.80 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | - | 82,761,817.10 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | - | 82,761,817.10 |
| 39200 | Биет хөрөнгө | - | 74,829,036.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | - | 47,171,501.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | - | (5,896,437.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | - | 39,282,700.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | - | (5,728,727.20) |
| 39300 | Биет бус хөрөнгө | - | 7,932,780.16 |
| 39301 | Програм хангамж | - | 8,422,370.16 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | - | (489,590.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | - | 4,902,731,056.70 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 5,771,805.09 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 5,771,805.09 |
| 41300 | Өглөг | - | 5,771,805.09 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 5,771,805.09 |
| 41311 | Цалингийн өглөг | - | 700,000.00 |
| 41312 | НДШ-ийн өглөг | - | - |
| 41313 | ХАОАТ-ын өглөг | - | 5,071,805.09 |
| 41360 | Бусад өглөг | - | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | - | 4,896,959,251.61 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | 4,896,959,251.61 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | - | 4,896,959,251.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 4,896,959,251.61 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | - | 4,902,731,056.70 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|----------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | - | 5,373,916,853.71 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 5,373,916,853.71 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | - | 5,373,916,853.71 |
| 120002 | Хүүгийн орлого | - | 52,485,821.96 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 5,321,431,031.75 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | - | 3,635,014.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | 5,317,796,017.75 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | 595,615,813.14 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 595,615,813.14 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 543,129,991.19 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 531,015,236.33 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 531,015,236.33 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 12,114,754.86 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | - | 12,114,754.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 52,485,821.96 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 52,485,821.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 52,485,821.96 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | - | 4,778,301,040.57 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | 118,658,211.04 |
| 14 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО | - | 118,658,211.04 |
| 145 | Бусад орлого (олз) | - | 118,658,211.04 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 118,658,211.04 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | - | 4,896,959,251.61 |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|----------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | - | 5,373,916,853.71 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 5,373,916,853.71 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | - | 5,373,916,853.71 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 52,485,821.96 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 5,321,431,031.75 |
| 120009 | Бусад орлого | - | 3,635,014.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | 5,317,796,017.75 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 682,703,497.16 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 682,703,497.16 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 630,217,675.20 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 630,217,675.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 630,217,675.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 52,485,821.96 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 52,485,821.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 52,485,821.96 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | 4,691,213,356.55 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | - | 856,582,836.79 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 856,582,836.79 |
| 222 | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | - | 856,582,836.79 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 290,451,264.83 |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | - | 471,255,000.00 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 94,876,571.96 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | (856,582,836.79) |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | - | 118,658,211.04 |
| 145 | Бусад орлого (олз) | - | 118,658,211.04 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 118,658,211.04 |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | - | 118,658,211.04 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | 3,953,288,730.80 |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 3,953,288,730.80 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| /төгрөг/ | | | | | |
|----------|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 1 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 8 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| 10 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | - | - |
| 11 | 2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | - | - | - | - |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 4,896,959,251.61 | 4,896,959,251.61 |
| 20 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 4,896,959,251.61 | 4,896,959,251.61 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт/ хэмнэлт | % |
|-----------------------|--|-------------------------|-------------------------|---------------------------|-------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,606,427,000.00 | 1,486,800,511.99 | 2,119,626,488.01 | 41% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 929,690,000.00 | 725,094,247.16 | 204,595,752.84 | 78% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 929,690,000.00 | 725,094,247.16 | 204,595,752.84 | 78% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 929,690,000.00 | 725,094,247.16 | 204,595,752.84 | 78% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 929,690,000.00 | 725,094,247.16 | 204,595,752.84 | 78% |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,676,737,000.00 | 761,706,264.83 | 1,915,030,735.17 | 28% |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,676,737,000.00 | 761,706,264.83 | 1,915,030,735.17 | 28% |
| 222001 | Тоног төхөөрөмж | 2,205,482,000.00 | 290,451,264.83 | 1,915,030,735.17 | 13% |
| 223001 | Бусад хөрөнгө | 471,255,000.00 | 471,255,000.00 | - | 100% |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,606,427,000.00 | 5,317,796,017.75 | (1,711,369,017.75) | 147% |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,606,427,000.00 | 5,317,796,017.75 | (1,711,369,017.75) | 147% |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 3,606,427,000.00 | 5,317,796,017.75 | (1,711,369,017.75) | 147% |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 3,953,288,730.80 | | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | | | |
| 610001 | Төсвийн байгууллага | | 1 | 1 | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | | | | |
| 620004 | Гэрээт ажилтан | | 7 | 5 | |

4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Код | ДАНСНЫ НЭР | Дүн |
|------|--|-----------------------|
| I | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| II | МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ОРЛОГО | |
| | Орлогын тохируулга: | |
| | Банкны хүүгийн орлого | - |
| | Тендерийн орлого | 3,635,014.00 |
| | Валютын ханшийн зөрүү | 118,658,211.04 |
| | Бусад авлага | - |
| III | ТОХИРУУЛСАН ОРЛОГЫН ДҮН | 122,293,225.04 |
| IV | МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРЛАГА | |
| | Зарлагын тохируулга: | |
| | Тендер, ажлын байрны зарын төлбөр | - |
| | Банкны үйлчилгээний хураамж | - |
| | Тендерийн зардал | - |
| | Бусад авлага | - |
| V | ТОХИРУУЛСАН ЗАРЛАГЫН ДҮН | - |
| VI | Эхний үлдэгдлээс тохируулсан зардал | |
| VII | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (I+II-IV) | |
| | Эцсийн үлдэгдлээс тохируулсан орлого | |
| VIII | ТОХИРУУЛГЫН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ (III-V-VI) | 122,293,225.04 |
| IX | Тохируулсан орлого зарлагаас үлдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (III-IV) | - |
| X | Тохируулсны дараа нийт зарлагад тооцох дүн (IV-V-VI) | - |
| XI | 2019 оны 12-р сарын 31-нийг хүртэлх хөрөнгө оруулалт | - |
| XII | Хөрөнгө оруулалтын дараа нийт зарлагад тооцох дүн (X+XI) | - |
| XIII | Төсвөөс санхүүжүүлэх цэвэр дүн | - |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020.4.13

Аудитын нэр:

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код:

САГ-2020/743/СТА-ТХН

Шалгагдсан байгууллагын нэр:

“Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал” төсөл

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын Байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|------------|---------------------------------------|---|-------------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Татварын ерөнхий газрын удирдлагууд болон сумдын татварын улсын байцаагчдад зориулан "Татварын шинэчлэл 2019 сургалт"-ыг 2019 оны 8 дугаар сард зохион байгуулсан ба сургалтад оролцогчдод олгосон 37,566.4 мянган төгрөгийн замын унааны зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. | 37,566.4 | Зөвлөмж | Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан | Г.Гэрэлтогтох С.Агьзул |
| 2 | Төслийн зээлийн гэрээний дагуу төслийн үйл ажиллагаа 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэхээр заасан боловч Сангийн яамнаас төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг 2019 оны 5 дугаар сард томилсонтой холбоотойгоор төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцролттой явагдаж байгаа нь Төслийн гэрээний хавсралт болох Төслийн удирдлагын гарын авлагын Төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд нийцэхгүй байна. | - | Зөвлөмж | Сангийн яам (Төсөл хэрэгжүүлэгч байгууллага) | |
| 3 | Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 92,772.3 мянган төгрөгийн е-баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтандаа хавсаргаагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байна. | 92,772.3 | Зөвлөмж | Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан | Г.Гэрэлтогтох С.Агьзул |
| 4 | Төсөл хэрэгжүүлэх нэгжийн түрээсэлж буй 120 м.кв оффисийн байрны түрээсийн 1м.кв-ийн сарын тариф нь 37.0 мянган төгрөг байна. Энэ нь ТӨБЗГ-аас баталсан түрээсийн хязгаараас 840.0 мянган төгрөгөөр өндөр буюу тайлант онд нийт 5,880.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг илүү төлсөн байна. | 5,880.0 | Зөвлөмж | Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан | Г.Гэрэлтогтох С.Агьзул |
| 5 | ТХН нь шилэн дансны сайтад нийт 11 мэдээллийг байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан буюу батлагдсан нийт төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна. | - | Зөвлөмж | Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан | Г.Гэрэлтогтох С.Агьзул |
| | Нийт дүн | 136,218.7 | | | |